

Агуулга

НЭГ.ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1 Төслийн талаарх мэдээлэл	2
1.2 Төслийн байршил.....	2
1.3 Хульжийн рашаан, шаврын талаар	3
1.4 Хульжийн рашаан, сувиллын талаар	4
1.5 2025 онд явуулсан үйл ажиллагааны мэдээлэл.....	6
ХОЁР.ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	7
2.1 Төслийн газарзүйн байршил	7
2.2 Булган аймгийн Могод сумын уур амьсгалын горим	8
2.3 Хөрсөн бүрхэвч	9
ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	12
3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	12
3.2 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	18
3.3 Ногоон байгууламж бий болгох, мод бут тарих төлөвлөгөөний биелэлт	19
3.4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	20
3.5 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	20
3.6 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	22
3.7 БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	23
3.8 БОМТ-ний хэрэгжилтийн зардлын нэгтгэл.....	24
ДҮГНЭЛТ	25

НЭГ.ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн талаарх мэдээлэл

Хүснэгт № 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл


№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр	“Хульж ресорт” ХХК	
2	Улсын бүртгэлийн дугаар	0411007083	
3	Төслийн нэр	Хульж ресорт	
4	Төслийн байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Булган
5		Сум/Дүүрэг	Могод
6	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Булган
7		Сум/Дүүрэг	Могод
8		Баг/Хороо	5-р баг, Эрхт, Хульж ресорт-н байр.
9	Захирлын хаяг	Нэр	Ц. Золбоо
10		Гар утас	99110742

1.2 Төслийн байршил

Булган аймгийн Могод сумын нутаг, Хульжийн халуун рашаан, Номгон уулын өвөрт “Рашаан, сувилал, амралтын цогцолбор”-ын барилга байгууламж нь нийт 3 га талбайг эзлэн сумын төвөөс 2 баруун зүгт 3 км, Улаанбаатар хотоос 327 километрт байрлана.

Хүснэгт № 2 Төслийн талбайн солбицол

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	102	57	55.225	48	15	59.986
2	102	57	50.386	48	16	3.61
3	102	57	57.624	48	16	7.917
4	102	58	2.462	48	16	4.293




Зураг № 1 Төслийн талбайн байршлын зураг

1.3 Хульжийн рашаан, шаврын талаар

Хульжийн халуун рашаан нь Хангайн шинэхэн өргөгдлийн хэсэгт газар хөдлөлийн идэвхтэй бүсэд байдаг азотат, сул эрдэсэжсэн, цахиурлаг халуун рашаан бөгөөд химийн найрлагаараа сульфат-натрийн бүлэгт багтдаг учир түүнийг Хульжийн төрөл гэж онцгойлон ангилдаг. Структур гидрогеологийн судалгааны үүднээс авч үзвэл халуун рашааны орд нь триас-юрийн настай андезит порфир, андезит базальт болох үндсэн чулуулгийн дээд хэсэгт сэвсгэр хурдсаар хучигдсан хоёр дахь орчинд бөмбөгөр гадаргуу үүсгэж тогтсон далд ан цав-судлын халуун рашааны орд болно. 1974–1975 онд гидрогеологийн судалгааны ажлыг хийж, тус халуун рашааны ордыг олж илрүүлээд тухайн халуун рашааны нөөцийг 202.6 м-ийн гүнээс оргилон гарах даралттай усны ундаргаар ашиглаж болох таамаг нөөцийг хоногт 397.4 шоо метр гэж тооцсон. 2020–2021 онд хийсэн судалгаагаар халуун рашааны ашиглалтын нөөцийг үйлдвэрлэлийн В зэрэглэлээр хоногт 501.12 шоо метр ашиглаж болохыг тооцоолсон байна.

Шаврын найрлага нь арьсны элдэв харшилд эергээр нөлөөлдөг нь хэрэглээний явцад тодорхой болсон бөгөөд Хар нуурын эргээс сумын байгаль орчны байцаагчийн зөвшөөрлийн дагуу жилд нэг удаа 2 тн-ыг татан авч эмчилгээнд ашигладаг.



Зураг № 2 Уст цэгүүдийн байршлын зураг

1.4 Хульжийн рашаан, сувиллын талаар

Тус рашаан, сувилал, амралтын цогцолбор нь анх 2017 онд байгуулагдан бөгөөд 2018 оноос эхлэн одоог хүртэл Хульжийн халуун рашаан, Номгон уулын өвөрт хүчил төрөгч баялаг ялгарсан эрүүл цэвэр агаарт амрагч, рашаан шаврын сувилал, шавар эмчилгээ, бариа засал амралт зугаалга хослуулан үйл ажиллагаа явуулж байна.

- Хульжийн рашааны хөлд байрлах алдарт Хар нуур нь эмчилгээний шинж чанар үзүүлэх нөлөөгөөрөө гадаад далай, дотоодын давстай нуурууд, Аварга тосонгийн нууртай төстэй үйлчилгээтэй. Үе мөч, хэрэх өвчин, хуян шар ус, гар хөлийн элдэв өвчин, яр шарх мэт арьс өнгөний, бөөр нурууны зэрэг өвчинг эдгээдэг. Нуурын эргэн тойрон нь рашааны ууршилтаас үүссэн өвөрмөц бичил орчинтой тул агаарт дэгдсэн химийн элементүүд нь цусны даралт буулгах, амьсгалын замаар дамжин биед шингэж эмчилгээний үр нөлөөг нэмэгдүүлнэ.
- Хульжийн рашаан нь Отгонтэнгэр, Шаргалжуут, Хүрэмт, Шивэрт, Хужиртын рашаантай ижил төсөөтэй эмчилгээний үр нөлөөтэй. Үе мөч, ууц нурууны өвчин, хаван, гэмтэл бэртэнги, арьсны төрөл бүрийн өвчин, бөөр, эмэгтэйчүүдийн өвчинд эмчилгээний үр нөлөө сайтай билээ. Олон төрлийн биологийн идэвхит нэгдлийг агуулсан бага эрдэсжилтэй, 53С хүртэл халуунтай, 8.4-8.5 PH шүлтлэгтэй хульжийн халуун рашаан бүхий ваннд орох, 20С доош градус бүхий сульфат, хлорид, натри, кальци зэрэг эрдэс, бор цахиурын хүчил бүхий шүлтлэг рашааныг эмчийн заавраар ууж хэрэглэнэ.

- Үүнээс гадна Булган аймгийн Эрүүл мэндийн газраас авсан сувиллын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн дагуу бариа болон аппарат эмчилгээг эмчийн хараа хяналтан дор хийдэг байна.

Стандартын шаардлага хангасан барилга байгууламж, тоног төхөөрөмж, инженерийн шугам сүлжээтэй. Энгийн болон хагас, бүтэн люкс өрөөнүүдэд амрагчдын ая тухыг хангах бүх л зүйлсээр тохижуулсан бөгөөд телевиз, интернэт, халуун хүйтэн ус, өрөөний үйлчилгээтэй, нэг ээлждээ дунджаар 70 хүн (хамгийн ихдээ 105) хүлээн авах хүчин чадалтай, жилийн 4 улирал үйл ажиллагаа эмчилгээ, бариа засал амралт зугаалга хослуулан үйл ажиллагаа явуулж байна. Мөн хуурай давсан саун, сагсны талбай, амралтаас 20 орчим км-ийн зайд байрлах Сэмжит бар хадны байгалийн үзэсгэлэнт газраар зочлох зэргээр амрагчид чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломжтой байна.

Дэд бүтцийн хувьд сумын төв хүрэх сайжруулсан шороон замын дэргэд, төвийн эрчим хүчинд холбогдсон, усан халаалтын зуухаар халаалт болон халуун усны асуудлыг шийдсэн, ахуйн хуурай хог хаягдлыг сумтай байгуулсан гэрээний дагуу хогийн цэг рүү ачуулдаг, ахуйн шингэн хаягдлыг бохирын ёмкостод хуримтлуулан Эрдэнэт рүү соруулж зайлуулдаг, гүний худгаар усны хэрэглээгээ хангадаг байна.



Зураг № 3 Төслийн талбайн агаар сансрын зураг

Хүний нөөц

Тус ресорт нь нийт 20 ажилтантай бөгөөд үүнээс:

- Өдөр тутмын үйл ажиллагаа хариуцсан менежер-1
- Захиалга бүртгэл хариуцсан менежер-1
- Их эмч-1
- Ахлах тогооч-2

- Бэлтгэгч-3
- Шавар эмчилгээний ажилтан-1
- Шавар эмчилгээний туслах ажилтан-1
- Бариа засалч-1
- Аж ахуй хариуцсан ажилтан-1
- Үйлчлэгч-1
- Ариун цэврийн өрөө хариуцсан үйлчлэгч-1
- Харуул-3
- Галч-3

1.5 2025 онд явуулсан үйл ажиллагааны мэдээлэл

Хульж ресорт рашаан сувилал нь 2025 оны 10 дугаар сарын 25-ний байдлаар нийт 257 өдөр ажиллаж 748 сувилуулагч, 156 амрагч хүлээн авч ажилласан байна.

ХОЁР.ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Төслийн газарзүйн байршил

Булган аймаг нь зүүн талаараа Сэлэнгэ, Төв, Орхон аймаг, өмнө талаараа Өвөрхангай аймаг, баруун талаараа Архангай, Хөвсгөл аймагтай, хойд талаараа ОХУ-лстай хил залган Монгол орны төв хэсэгт Орхон, Сэлэнгэ голын сав газарт оршино. Булган аймаг нь Улаанбаатар хотоос 336 км, Эрдэнэт хотоос 60 км зайтай байрлана. Булганхан, Бүрэгхангай, Дулаанхан, Бүтээл, Хантай зэрэг ой хөвчит уул нуруудтай, Уран тогоо, Тулга, Бүрхээр, Жалавч зэрэг унтарсан галт уул нь улсын тусгай хамгаалалтад байдаг.

Газрын гадарга:

Судалгааны бүс нутагт дунд зэрэг болон нам уулсын, дов гүвээрхэг тэгш гадаргуу ялгагдана. Дунд зэргийн уулын гадаргуу нь районы баруун хэсэг дэх Улаан Хошуу уул болон Шар Чулуут уул юм. Энэ уулс нь 1223-1397 м үнэмлэхүй өндөртэй ба харьцангуй өндөршилт нь 100-150м байдаг. Голчлон доод эрт төрмөлийн настай хурдас тархсан. Энэ нутаг дэвсгэрт намхан уулсын гадаргуу зонхилдог ба энэ нь дунд уулсыг эмжээрлэн хүрээлсэн байдалтайгаар оршино. Үнэмлэхүй өндөр нь 1092 м. Дов гүвээрхэг гадаргуу нь уулс хоорондын хотгорт болон голын хөндийн хэсэгт тархсан 950-1000 м-ийн үнэмлэхүй өндөртэй 20 м-ийн харьцангуй өндөршилттэй байдаг.


Төслийн талбай нь далайн түвшнээс дээш 1450 орчим метрийн үнэмлэхүй өндөрт байрлаж, газрын гадаргын налуу буюу хэвгий 0-2.6⁰ (градуст) байна.

Булган аймгийн уур амьсгалын горим

Булган аймаг нь манай орны төв хэсэгт Орхон Сэлэнгийн сав газарт, Хангай-Хэнтийн уулт их мужид багтах орших бөгөөд нутагт нь Булганхан, Бүрэгхангай, Дулаанхан, Бүтээл, Хантай Дархан хаан зэрэг ой хөвчит уул нуруудтай 48,733.00 км² нутаг дэвсгэртэй. Булган аймгийн нутагт Сэлэнгэ, Орхон, Хануй зэрэг том голууд урсах бөгөөд Харгал, Хунт, Айрхан зэрэг нуурууд түүнчлэн Хульж, Хунт, Хануйн, Асгатын зэрэг рашаан бий.

Хангай-Хэнтийн их мужийн уул нурууд зонхилгогч баруун хойд зүгийн агаарын урсгалаар илэрдэг чийгийг авах талаар тохиромжтой байрласан болохоор бусад их мужуудыг бодвол илүү чийглэг юм. Ерөнхийдөө Булган аймаг нь уур амьсгалын мужлалын хувьд чийглэг, нэн сэрүүн нэн хүйтэн; чийглэгдүү, сэрүүн нэн хүйтэн бүсүүдэд оршдог гэж үздэг.

Бид энэхүү судалгаандаа Булган аймгийн уур амьсгалын хандлагыг “Статистикийн мэдээллийн нэгдсэн сан”-гийн 2005-2019 оны хоорондох агаарын температур, хур тунадасны олон жилийн мэдээ, жилийн явцыг “Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн”-гийн архиваас Булган (ДТД-1219м), Орхон (ДТД-1066м), Баяннуур (ДТД-1523м), Дашинчилэн (ДТД-1018м), мөн Хутаг (ДТД-312м) цаг уурын станц, харуулуудын 2013-2018 оны агаарын температур, хур тунадас болон салхины хурд гэсэн статистик үзүүлэлтүүдийг ашиглалаа.



Зураг № 4 Агаарын температур болон хур тунадасны олон жилийн түүхэн өгөгдөл

2005-2019 оны олон жилийн явцаас харахад жилийн агаарын дундаж температур ойролцоогоор 0.5°C -аар дулаарсан бөгөөд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор тасралтгүй нэмэгдсээр буй нь Зураг 5-т харагдаж байна. Энэ хугацаанд хамгийн хүйтэн жил 2011 онд -1.8°C байсан бол хамгийн дулаан жил 2007 онд 1.6°C хүрч байжээ. Харин хур тунадасны олон жилийн өөрчлөлтийн хандлагаас үзвэл өссөн болон буурсан тодорхой хандлага илрээгүй бөгөөд жилийн нийлбэр хур тунадасны хэмжээ 254...410 мм-ийн хооронд хэлбэлзсэн байна.

2.2 Булган аймгийн Могод сумын уур амьсгалын горим

Булган аймгийн н Могод сум нь эх газрын эрс тэс уур амьсгалтай. Агаарын үнэмлэхүй бага - 36 хэм, агаарын үнэмлэхүй их $+36$ хэм, ихэвчлэн баруун хойноосоо салхилдаг. Жилд дунджаар 260-300 мм тунадас унадаг. 1 дүгээр сарын дундаж температур -24°C , 7 дугаар сарын дундаж температур $+26^{\circ}\text{C}$, жилийн дундаж салхины хурд 4-9 м/с, хур тунадасны нийлбэр 260 мм. Өвөл ихэнхдээ тэнгэр цэлмэг, тогтвортой, хүйтэн, цас болон салхины хүч бага байна. Агаарын хэм нэгдүгээр сард -46 хэм хүрдэг. Салхи нь зонхилон 1.9-2.5 м/с хурдтай, баруун хойд зүгээс салхилдаг. Хаврын улиралд цаг агаар тогтворгүй, агаарын хэм түргэн өөрчлөгдөж, хоногийн дулааны хэлбэлзэл ихсэж, өдөртөө дулаан, шөнөдөө хүйтэн болж, шороон шуурга ихэсдэг. Зун хамгийн дулаан бөгөөд удаан үргэлжилдэг улирал юм. Үнэмлэхүй дулаан нь $+40.5$ хэмд хүрдэг. Намрын улиралд агаарын температурын хэлбэлзэл их боловч хавраас өөр байдаг. Цаг агаар тогтворгүй болж салхины хүч зунаас нэмэгддэг.

Байгальд гарч буй хувьсал, байгалийн иж бүрдлийн өөрчлөлтөд уур амьсгалаас үзүүлэх нөлөө хамгийн чухал байр суурийг эзэлдэг. Уур амьсгал гэдэг маш өргөн утгатай бөгөөд түүнд сав газрын агаарын ба хөрсний дулаан, хүйтэн, хур тунадас, салхи, нарны гэрлийн цацралт, ууршилт зэрэг уур амьсгалын олон нэгжүүд багтах боловч тэдгээр нь газарзүйн бусад нөхцөлүүдтэй хамтран шууд буюу шууд бусаар нөлөөлнө

Булган аймаг нь Төв Азийн гүнд Хангайн нурууны салбар уулсаар хүрээлэгдсэний улмаас хур тунадас бага төдийгүй хэлбэлзэл ихтэй эх газрын эрс тэс уур амьсгалтай, ойт хээрийн шинж ноёрхож байдаг. Агаарын температурын хувьд ихээхэн ялгаатай эрс тэс сэрүүвтэр чийглэг, үнэмлэхүй дулаан 34.8 хэм, үнэмлэхүй хүйтэн 44.1 хэм, жилийн дундаж


тунадас 324 мм боловч зарим жил 500 мм-ээс дээш байдаг. Хоногийн температурын хэлбэлзэл 1-р сарын дундаж температур (19 -24) хэм хүйтэн, 7-р сард (14-19) хэм дулаан, жилд дунджаар 220-420 мм хур тунадас унадаг. Салхины дундаж хурд 2.2 м/с, газрын гадаргын өндөнтр нам жигд бишээс болж агаарын даралтын хуваарилалт жигд бус байна. Агаарын даралт өвлийн улиралд 1 сард хамгийн их утгатай байснаа аажмаар буурч зун 7 сард хамгийн бага хэмжээндээ хүрдэг байна.

Аймгийн нутгийг чийг, дулааны хангамжийн хувьд 4 мужид хувааж үздэг.


- а. Чийглэг хүйтэвтэр муж: 1600 м-ээс дээш өргөгдсөн нутаг
- б. Чийглэгдүү сэрүүн муж: 1200-1600 метр өргөгдсөн ойт хээрийн бүсийн нутаг
- в. Хуурайдуу сэрүүвтэр муж: 1200 м-ээс доош орших, голын хөндий нутгууд
- г. Хуурай дулаавтар муж: цөлөрхөг хээрийн бүсэд хамаарах нутаг ордог

2.3 Хөрсөн бүрхэвч


Хээрийн судалгаа болон лабораторийн шинжилгээний үр дүнг үндэслэн төслийн талбайд бүхэлдээ уулын хар хүрэн хөрс тархжээ.



Зураг № 5 Төслийн талбайн хөрсний хэв шинжийн зураг



Зураг № 6 Төслийн талбайн районы өндөршлийн зураг (метр)



Зураг № 7 Төслийн талбайн районы газрын гадаргын налууугийн зураг (градус)

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Тухайн рашаан шаврын сувилал амралтын цогцолборын төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл бага эрчимтэй боловч рашаан сувиллын газрын ахуйн шингэн хаягдал, хатуу хог хаягдлаас үзүүлэх нөлөөлөл, газрын доорх ус болон хөрс, ургамлан бүрхэвч зэрэг бусад дам нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах үүднээс төслийг хэрэгжүүлэхдээ дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүснэгт №3 Агаар орчин

АГААР ОРЧИН		
№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө	Биелэлт
1	Уурын зуухны янданд усан шүүлтүүр байрлуулах, тодорхой давтамжтай сольж байх /эсвэл үнс баригч утаа шүүгч хийх/	“Эвридэй ферм” ХХК-тай гэрээ байгуулан нарны эрчим хүчээр уурын зуухаа шийдэхээр төлөвлөж байна. Судалгааны ажил 30%-үнийн санал авсан байгаа. Үнийн саналыг зургаар оруулав /Зураг №8/.
2	Үнс хадгалах битүүмжлэл бүхий сав бий болгох, хоёрдогч түүхий эд байдлаар бусдад нийлүүлэх боломж судлах	Үнс хадгалах савыг битүүмжлэлтэй саваар сольсон. Зургийг доор оруулав. /Зураг №9/
3	Нүүрсний талбайг битүү болгох	Нүүрсний талбайг хашаалж битүү болгосон. Зургийг доор оруулав /Зураг №10/.
4	Ахуйн хуурай хог хаягдлыг ангилан хаях, гадуур нь хашаа хийх	Ахуйн хуурай хог хаягдал ангилан хаях битүүмжтэй хогийн савыг өөрсдийн дотоод бололцоогоороо хийж гүйцэтгэсэн. Зургийг доор оруулав /Зураг №11/.



ЭВРИДЭЙ ФЕРМ

Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14-хороо
Энхтайвны өргөн чөлөө, Бридж плаза төв, 409 тоот
Утас : +976 94663222 +976 94773222 Имэйл : ed_@farmdo.mn



Үйлчлүүлэгч :

120 кВт НАРНЫ ЗАЙН СИСТЕМ ҮНИЙН САНАЛ



Нарны Дэлгэцийн Чадал : **100.10 кВт**
Хуримтлуурын Багтаамж : **100.00 кВт.Цаг**
Өдөрт Үйлдвэрлэх Эрчим Хүч : **624.54 кВт Цаг**
Сард Үйлдвэрлэх Эрчим Хүч : **18982.96 кВт Цаг**

№	Бараа материал	Марк Тип	Тоо хэмж	Нэгжийн үнэ	Дүн
1	Нарны Дэлгэгч	JNKO SOLAR 550W /JKM550M-72HL-V/ 26 kg 2226x1134x30mm	180	₮ 420,000.00	₮ 75,600,000.00
2	Инвертер	Инвертер /SUN-50K-SG04LP3-EU, 3P, Hybrid/	1	₮ 35,000,000.00	₮ 35,000,000.00
3	Батарей	Lead Acide 200Ah 12V SH-200AH	20	₮ 3,200,000.00	₮ 64,000,000.00
4	Суурь	Solar Stand Kits-Aluminium	ком	₮ 49,400,000.00	₮ 49,400,000.00
5	Бетон хөл		100	₮ 72,000.00	₮ 7,200,000.00
6	Тоноглосон щит	Цэнэг шалхагч Гал хамгаалагч Соронзон контактор бүхий щит	1	₮ 300,000.00	₮ 300,000.00
7	Газардуулагын байгууламж		ком	₮ 8,000,000.00	₮ 8,000,000.00
8	Холболтын кабель	N12222 4mm2 Тогтмол хүчдэлийн кабель [м]	500	₮ 3,000.00	₮ 1,500,000.00
9	Угсралт суурьлуулалт			₮47,646,500.00	₮56,850,000.00
				НИЙТ ТӨСӨВИЙН ДҮН	₮ 297,850,000.00

Үнийн саналын хүчинтэй хугацаа 21 хоног
УБЦТС-тэй эрчим хүч худалдах гэрээ хийхтэй холбоотой бүхий л бараа материал, зураг төслийн зардал уг гэрээнд тусгагдаагүй болно
Үнийн саналд тээврийн зардал багтаагүй болно
Суурилуулах хугацаа төлбөр төлөгдснөөс хойш 14-28 хоног
Үнийн дүнд буцаалтгүй НӨАТ болон буцаалттай НӨАТ-ын баримт олгоно


Зураг № 8 Нарны зайн үнийн санал



Зураг № 9 Үнсний савыг битүүмжлэлтэй болгосон байдал



Зураг № 10 Нүүрсний талбайг хашаажуулсан байдал



Зураг № 11 Хогийн цэгийг битүүмжилсэн байдал

Хүснэгт № 4 Усан орчин

УСАН ОРЧИН		
№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө	Биелэлт
1	Рашаан болон ундны усны эх үүсвэрийг тоолууржуулах	Тоолуурын зургийг доор оруулав /Зураг №12/. Баталгаажуулалтын гэрээ болон төлбөрийн баримтыг хавсралтаар орууллаа.
2	Эрүүл ахуйн бүс тогтоох	Булган аймгийн Могод сумын ИТХ-ын ээлжит 8-р хуралдааны “Хульжийн халуун рашааны хамгаалалтын бүс тогтоох тухай” тогтоолоор батлагдсан хориглолтын бүсийг байгуулж хамгаалалтын хашаа барьсан.



Зураг № 12 Усны тоолуурын зураг



Зураг № 13 Эрүүл ахуйн бүсийг хашаалсан байдал

Хүснэгт № 5 Хөрсөн бүрхэвч

ХӨРСӨН БҮРХЭВЧ		
№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө	Биелэлт
1	Ахуйн хатуу хогийн цэгийг хашаажуулах, битүү саванд хадгалах	Ахуйн хуурай хог хаягдал ангилан хаях битүүмжтэй хогийн савыг өөрсдийн дотоод боллоцгоогоороо хийж гүйцэтгэсэн.

Хүснэгт № 6 Ургамлан нөмрөг, амьтны аймаг

УРГАМЛАН НӨМРӨГ, АМЬТНЫ АЙМАГ		
№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө	Биелэлт
1	Ногоон байгууламж бий болгох	Төлөвлөгөөний хүрээнд хус мод-8ш, шар агч-4ш, яргай-6ш, мөнгөлөг улиас-8ш, өрөл, монос, хайлаас нийт 200ш мод тарьсан. Мод тарьсан газрын солбицол болон зургийг доор оруулав /Зураг №14/.
2	Сувиллын ажилчид болон амрагч үйлчлүүлэгчид хууль бус ан агнуур хийхгүй байх, хийсэн тохиолдолд хүлээх торгууль хариуцлагын талаар ухуулга сургалт сурталчилгаа хийх	Сувиллын ажилчид болон амрагч үйлчлүүлэгчид хууль бус ан агнуур хийхгүй байх, хийсэн тохиолдолд хүлээх торгууль хариуцлагын талаар ухуулга сургалт сурталчилгаа тогтмол хийж ажилдаг.



Зураг № 14 Мод тарьж буй байдал

3.2 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт № 7 Хог хаягдал

ХОГ ХАЯГДАЛ		
№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө	Биелэлт
1	Үнс, нүүрс хадгалах савыг битүү болгох	Үнс, нүүрс хадгалах савыг битүү болгосон.
2	Ахуйн хог хаягдлын ангилан ялгах сав бий болгох, хашаажуулах	Ахуйн хог хаягдлын ангилан ялгах сав бий болгосон, хашаажуулсан.
3	Хогийн цэг, жорлонд ариутгал халдваргүйжүүлэлт хийх	Ариутгалыг тогтмол хийж гүйцэтгүүлж байгаа болно. Зургийг доор оруулав /Зураг №15/. Гэрээг хавсралтаар оруулав.



Зураг № 15 Хогийн цэг болон ариун цэврийн өрөөнд ариутгал хийж буй байдал

“Хульж ресорт” ХХК-ий ажилчид нь нийгмийн хариуцлагын хүрээнд ойролцоох газруудад ил задгай хаягдсан хог хаягдлыг цэвэрлэж зайлуулах ажлыг тогтмол хийж гүйцэтгэдэг.



Зураг № 16 Хог түүж буй зураг

3.3 Ногоон байгууламж бий болгох, мод бут тарих төлөвлөгөөний биелэлт

Газрын тухай хуульд заасны дагуу газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана. Иймд тус эзэмшил газрын 0.3 га хүртэл газрыг ногоон байгууламжаар тохижуулах боломжтой. 1 жилд 50ш мод бутыг тарьж ургуулан, барилга байгууламжийн сууриас бусад талбайг зүлэгжүүлэн ургамлан нөмрөгийг арчлах услах ажлыг жил бүр хийнэ. Энэхүү ажилд 1 ширхэг мод бутны суулгацыг жил бүр 5.0 мян.төгрөгөөр худалдан авч суулгана гэж тооцвол 2025 онд 250.0 мян.төгрөг төлөвлөсөнөөс 2025 онд нийт 200ш мод бут тарьж арчилж байгаа.

Хүснэгт № 8 Мод тарьсан газрын солбицолын цэгүүд

МОД ТАРЬСАН СОЛБИЦОЛ		
№	Уртраг	Өргөрөг
1	102° 57' 53.25"	48° 16' 02.64"
2	102° 57' 52.46"	48° 16' 03.31"
3	102° 57' 52.86"	48° 16' 02.95"
4	102° 57' 53.85"	48° 16' 02.21"
5	102° 57' 54.30"	48° 16' 01.85"
6	102° 57' 57.78"	48° 16' 02.82"

3.4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Хүснэгт № 9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт		Зардал (төг)	Тайлбар
Агаарын шинжилгээ	Гадаад орчин	504,000	Булган аймгийн Булган сумын УЦУОШГ-ын БО-ы шинжилгээний лабораторид 2025/08/28-ны өдөр SO ₂ , NO ₂ шинжлүүлсэн. Шинжилгээний хариу зөвшөөрөгдөх хэмжээнд байна. Хавсралтаар хариу болон төлбөрийн баримтыг оруулав.
	Дотоод орчин		
Усны шинжилгээ	Унд ахуй		
Хөрсний шинжилгээ	Кемп		Булган аймгийн Булган сумын УЦУОШГ-ын БО-ы шинжилгээний лабораторид 2025/08/27-ны өдөр агрохимийн шинжилгээ хийлгэсэн. Хавсралтаар хариу болон төлбөрийн баримтыг оруулав
	Хогийн цэг		

3.5 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Тус ажлын хүрээнд галын буланг шинэчлэн сайжруулсан бөгөөд төлбөрийн баримтыг хавсралтаар орууллаа.



Зураг № 17 Галын булан

Эмчилгээний болон амрах өрөө тасалгаа, нийтийн үйл ажиллагаа зохион байгуулдаг талбайнууд, гал тогоо, агуулах зэрэгт ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж байна.



Зураг № 18 Ариутгал, халдваргүйжүүлэлт хийж буй байдал

3.6 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт № 10 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт

1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөж ажиллаж байгаа.
2	Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулсан зургийг доор оруулав. Хавсралтаар төлбөрийн баримтыг орууллаа.
3	Газрын төлбөрийг тогтмол төлж байх	Газрын төлбөр төлсөн.



Зураг № 19 Галын болон болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх сургалтын үеийн зураг

3.7 БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Хүснэгт № 11 БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

№	БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов
---	--	-------------------------------	------------------	---------------

1	Булган аймгийн Могод сумын 5-р багийн иргэд, сумын байгаль хамгаалагч, байгаль орчны ажилтан	Уулзалт, санал асуулга	БОМТ болон хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	10-11-р сар
2	Булган аймгийн БОАЖГ-т тайлангаа хүргүүлэх	Тайлангийн эх хувь, албан бичиг	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх Дүгнүүлэх	11.01 12.31
3	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	Тайлангаа баталгаажуулах	Тухайн жилийн БОМТ-ий хэрэгжилтийн талаар	12.31

3.8 БОМТ-ний хэрэгжилтийн зардлын нэгтгэл

Хүснэгт № 12 БОМТ-ний хэрэгжилтийн зардлын хүснэгт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	2025 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах ажлын төлөвлөгөө	2,184,500
2	Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд мод тарих	880,000
3	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	504,000
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,147,000
5	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	450,000
6	БОМТ-ий хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	-
7	Ус ашигласны төлбөр	1,716,000
Нийт		6,881,500

ДҮГНЭЛТ

“Хульж ресорт” ХХК-ийн Булган аймгийн Могод сумын нутагт орших рашаан шаврын сувилал, амралтын цогцолборын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан хийж гүйцэтгэлээ.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлж тухайн онд хийсэн ажлаа холбогдох газруудаар хянуулж батлуулах шаардлагатай байгаа болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2025 онд нийт 3,925.0 мян.төг зарцуулахаар төлөвлөснөөс **6,881.5** мян.төг зарцуулсан байна.



ХУЛЬЖ РЕСОРТ ХХК-д

**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

Арцатын 624, 23 дугаар хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17100
Утас: 26 61 71, Цахим шуудан: contact@met.gov.mn,
Цахим хуудас: www.met.gov.mn

2024. 06.03 № 12/2024
танай _____-ны № _____-т

**Ерөнхий үнэлгээний дүгнэлт
хүргүүлэх тухай**

Танай компаниас ирүүлсэн Булган аймгийн Могод сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй “Хульж ресорт” рашаан, сувилал, амралтын цогцолбор төсөлд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам”-д заасан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийж, уг төсөлд батлагдсан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэв.


Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах чиглэлийг харгалзан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж 2024 оны 4 дүгээр улиралд багтаан тус яаманд ирүүлэхийг үүгээр мэдэгдье.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудсыг хавсаргав.

Хавсралт 6 хуудастай.

ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

Г.ЭНХМӨНХ



**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ХУУДАС**

2024 оны 05 дугаар сарын 24

Улаанбаатар хот

Төслийн дугаар

Дугаар 2024/ӨМ-84

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: Хульж ресорт ХХК Булган аймгийн Могод сум, 5-р баг, Эрхт ресортын байр

Холбоо барих утас: : (976) 99185423

Төслийн нэр: “Хульж ресорт” рашаан, сувилал, амралтын цогцолбор

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил: Булган аймгийн Могод сумын төвөөс 1 км орчимд Хульжийн халуун рашаан, Номгон уулын өвөрт оршино

Орон нутгийн санал: Булган аймгийн Могод сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 1/172 дугаартай албан бичиг, Е-Монголиа цахим бүртгэлийн О77-2404-000230 хүсэлтийг тус тус үндэслэв.

Газарзүйн байршил, координат:

Д/д	Уртраг	Өргөрөл	Нийт
1.	102 57 55.225	48 15 59.986	29976 м2
2.	102 57 50.386	48 16 3.61	
3.	102 57 57.624	48 16 7.917	
4.	102 57 2.462	48 16 4.293	

	Ерөнхий үнэлгээний гол шалгуурууд	Нийцсэн	Нийцээгүй	Нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай	Үндэслэл тайлбар
Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн нийцэл	Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчныг хамгаалах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн холбогдох заалт	Тийм			
Төрийн бодлого, шийдвэрийн нийцэл	Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн холбогдох заалт	Тийм			
Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд	Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх (урсац бүрэлдэх эх, ойн болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хилийн хамгаалалтын бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар г.м)	Тийм		Тийм	
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын	Тийм		Тийм	

	өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтгий эсэх				
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн, сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй газар байгаа эсэх			Тийм	
	Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсгэх эсэх			Тийм	
	Агаарын чанар				
	Бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулах, эсэх			Тийм	
	Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх, эсэх			Тийм	
	<p>1. Төслийн явцад орчны бохирдлыг тооцож, үйл ажиллагаанаас агаарт үзүүлж болзошгүй нөлөөллийг тодорхойлох,</p> <p>2. Төслийн үйл ажиллагаанаас гарах хатуу, шингэн хог хаягдлын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тогтоож, арилгах, бууруулах, байгаль орчинд халгүй аргаар зайлуулах арга хэмжээг төлөвлөх,</p>				
	Усан орчин				
Төслийн байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх, эсэх			Тийм	
	Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх			Тийм	
	Гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэх, эсэх			Тийм	
	<p>1. Барилга байгууламж барихтай холбоотойгоор газрын доорхи болон гадаргын усны нөхцөл байдлыг тодорхойлж, төслийн үйл ажиллагааны явцад ашиглах усны эх үүсвэр, хэмжээг тодорхойлж, түүнтэй уялдуулан нарийвчилан тооцох;</p> <p>2. Төслийн үйл ажиллагаанаас усны нөөц, горим чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоож, түүнд тавих хяналт, хугацаа, хөрөнгө зардлыг нарийвчилан тооцох;</p> <p>3. Усны алдагдлыг багасгах, усыг хэмнэлттэй ашиглах технологийн хувилбарыг судалж, тайланд тусгах;</p> <p>4. Аялал жуучлалын үйл ажиллагаанаас гарч байгаа бохир усны хэмжээ, найрлагыг нарийвчлан тогтоож, түүнийг байгаль орчинд халгүйгээр зайлуулах цэвэршүүлэх, дахин ашиглах боломж, арга хэмжээ, түүнд шаардагдах зардлыг тооцох;</p> <p>5. Төсөл хэрэгжиж байгаа нутаг дэвсгэр нь Усны тухай хууль, тогтоомж болон бусад хууль тогтоомжоор хориглосон хязгаарласан бүсэд орж</p>				

байгаа эсэхийг тодорхойлж бүсийн дэглэмийг зөрчихгүй байх талаар зөвлөмж боловсруулж тайланд хавсаргах,				
Хөрсөн бүрхэвч				
Хөрсөн бүрхэвч эвдрэх, эсэх			Тийм	
Хөрс бохирдуулах эсэх			Тийм	
Хөрс доройтох, цөлжих эсэх			Тийм	
<p>1. Төслийн үйл ажиллагааны явцад хөрс, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнийг багасгах, арилгах, цөлжилт, хөрсний эвдрэлээс урьдчилан сэргийлэх арга зам, түүнд шаардагдах хөрөнгө зардлыг төлөвлөх;</p> <p>2. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үүсэх бохирдлын эрсдэлтэй цэгийг нарийвчлан тогтоож шинжилгээнд хамруулах бохирдуулагч бодисын нэр төрлийг тодорхой тусгаж, түүнд шаардагдах хөрөнгө зардлыг төлөвлөх;</p> <p>3. Хатуу, шингэн хог хаягдал, техник технологийн ашиглалтын явцад хөрс бохирдуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх; Олон салаа зам гаргах, хөрс бохирдох, эвдрэхээс сэргийлэх, тогтсон нэг орц, гарцыг тогтоох;</p>				
Ургамлан нөмрөг				
Ургамлан нөмрөг, ой мод өртөх эсэх			Тийм	
Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлс өртөх, эсэх			Тийм	
<p>1. Төслийн үйл ажиллагаа явуулахад өртөх талбайн ургамлын нэр төрөл, тархалтыг тогтоох, ховор болон нэн ховор ургамал байгаа эсэх талаар дүгнэлт гаргаж, хэрэв тэдгээр нь төслийн үйл ажиллагааны явцад өртөхөөр байвал түүнийг хамгаалах, болон шилжүүлэх, плантац байгуулах арга хэмжээ авах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх түүнд шаардагдах хөрөнгө зардлыг төлөвлөх;</p> <p>2. Эдэлбэр газрын орчны ногоон байгууламжийг бууруулахгүй сөрөг нөлөөлөлд өртүүлэхгүй үйл ажиллагаа явуулах, шаардлагатай газарт ногоон байгууламж байгуулах талаар мэргэжлийн түвшний зөвлөмжийг шаардагдах зардлын хамт боловсруулж, тайланд тусгах;</p> <p>3. Төслийн үйл ажиллагааны улмаас сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй биологийн төрөл зүйлийн бүрэлдэхүүнийг нарийвчилан тогтоож, хамгаалах арга замыг цогц байдлаар шийдэхэд заавар, зөвлөгөө өгөх, тайланд тусгах;</p> <p>4. Төсөл хэрэгжиж байгаа нутаг дэвсгэр нь Ойн тухай хууль, тогтоомж болон бусад хууль тогтоомжоор хориглосон хязгаарласан бүсэд орж байгаа эсэхийг тодорхойлж бүсийн дэглэмийг зөрчихгүй байх талаар зөвлөмж боловсруулж тайланд хавсаргах,</p>				
Амьтны аймаг				
Зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах, эсэх			Тийм	
Ховор, нэн ховор амьтан өртөх, эсэх			Тийм	
<p>1. Төслийн үйл ажиллагааны улмаас амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойлж, нөлөөлөлд өртөж болзошгүй биологийн төрөл</p>				

	зүйлийн бүрэлдэхүүнийг нарийвчилан тогтоож, амьтны гүйдлийн зам болон хамгаалах арга замыг цогц байдлаар шийдэх заавар, зөвөлгөө өгөх, тайланд тусгах;			
Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Нутгийн оршин суугчид			
	Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх, эсэх			Тийм
	Нутгийн оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөлөлтэй, эсэх			Тийм
	Нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар байгаа, эсэх			Тийм
	Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх, эсэх			Тийм
	Түүх, соёлын биет өв			
	Сөрөг нөлөөлөлд өртөх түүх, соёлын үнэт зүйлс бий эсэх			Тийм
	Төсөл хэрэгжих бүс нутгийн түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээг холбогдох зардлын хамт тайланд тусгах;			
	Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл			
	Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх			Тийм
Төслийн бүх үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэх эсэх			Тийм	
	Төслийн үйл ажиллагаа болон байгалийн гамшгаас үүдэн гарч болзошгүй ослын үнэлгээ хийж, ослоос сэргийлэх, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг тодорхойлж тайланд тусгана.			
Нэгдсэн дүгнэлт:				
Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлээр уг төсөлд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын “Аргачлал батлах тухай” 2014 оны А-117 дугаар тушаалын хавсралтын дагуу хийлгэн, нарийвчилсан үнэлгээний тайланг тус яаманд 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлж, шүүмж хийлгэн, шийдвэр гаргуулах шаардлагатай гэж үзлээ.				
Онцгойлон анхаарах зүйлс:				
1. Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон Байгаль орчны сайдын 2010 оны 156 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал”-ын дагуу төслийн үйл ажиллагаанаас ургамал, хөрс, амьтан, агаар орчинд учруулах хохирлыг байгалийн бүрэлдэл тус бүрээр тогтоож, улмаар тухайн газрыг эвдрэлд оруулснаар учирч болох хохирлыг урьдчилан тооцож нийлбэр үнэлгээ гарган төслийг хэрэгжүүлэх байгаль орчны хариуцлагын болон эдийн засгийн үндэслэлийг тодруулж дүгнэлт гаргах;				
2. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээгээр тогтоогдсон тухайн орчны байгалийн нөөц, хүний эрүүл мэндэд төслийн үйл ажиллагаанаас шууд болон шууд бусаар нөлөөлөх сөрөг нөлөөллийг нарийвчлан тогтоож, шаардагдах зардлыг боловсруулах;				
3. Төслийн үйл ажиллагааны явцад гарах ахуйн болон аюултай хог хаягдал, ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, тусгай ангиллын хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй аргаар цуглуулах, ангилан ялгах, дахин ашиглах, устгах, зайлуулах аргыг нарийвчлан тооцож, төслийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг болгон				

хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр устгах, зайлуулах талаар зөвлөмж боловсруулах;

4. “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 10¹ дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 жил тутамд төслийн үйл ажиллагаанд хийх асуудлыг холбогдох зардлын хамт тайланд тусгах;

5. Төслийн үйл ажиллагааны явцад унд ахуйд ашиглах цэвэр усны хэрэглээний хэмжээг эх үүсвэртэй уялдуулан, цогцолборын үйл ажиллагаанаас гарч байгаа бохир усны хэмжээ, найрлагыг нарийвчлан тогтоож, түүнийг байгаль орчинд халгүйгээр зайлуулах цэвэршүүлэх, дахин ашиглах боломж, арга хэмжээ, түүнд шаардагдах зардлыг нарийвчлан тооцох

6. БОННУ-нд байгаль орчинд ээлтэй, олон улсын стандартад нийцсэн технологийг ашиглах талаар заавар, зөвлөмжийг боловсруулах; (Ариун цэврийн байгууламж, дулааны асуудал...)

7. Эдэлбэр газрын орчны ногоон байгууламжийг бууруулахгүй сөрөг нөлөөлд өртүүлэхгүй үйл ажиллагаа явуулах, шаардлагатай газарт ногоон байгууламж байгуулах төсөл боловсруулж, хэрэгжүүлэх;

8. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төслийн хүчин чадал, төслийн үйл ажиллагааны өрнөлтийн байдалтай уялдуулан тооцож, төлөвлөх;

9. Холбогдох хуулинд нийцүүлэн эрх бүхий байгууллагаар баталгаажсан барилга байгууламжийн зураг төсөл, тухайн газарт хэрэгжих төслийн талаарх мэдээлэл, шинжилгээний дүн мэдээг тус тус тайланд хавсаргах;

10. Нарийвчилсан үнэлгээ хийх явцад уг төсөл хэрэгжиснээр байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийн талаар болон БОННУ-ний ажлын тайланг төсөл хэрэгжих багийн ИНХ-аар хэлэлцүүлж, хурлын тогтоол, тэмдэглэлийг тайланд хавсаргах;

11. “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, төсөл хэрэгжүүлэгчид танилцуулан нарийвчилсан үнэлгээний тайланд тусгах;

Бусад зүйлс:

1. Нарийвчилсан үнэлгээний тайланд шүүмж хийлгэн дүгнэлт, шийдвэр гаргуулах асуудлыг ерөнхий үнэлгээгээр тогтоосон хугацаанд хэрэгжүүлэх;

2. Ерөнхий үнэлгээнд заасан чиглэл, нөхцөл, болзлоос өөр үйл ажиллагаа явуулах болон төсөлд өөрчлөлт орох, эсхүл өргөтгөх, шинэ тоног төхөөрөмж, технологи нэвтрүүлэх бүрт Ерөнхий үнэлгээнд хамрагдаж байх;

Ерөнхий үнэлгээ хийсэн:

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМНЫ ШИНЖЭЭЧ**



Ө.МӨНХБАЯР

Ерөнхий үнэлгээний үр дүнг зөвшөөрсөн:
“ХУЛЬЖ РЕСОРТ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.ЗОЛБОО



Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн
А/154 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар 0004179

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: *"Хэвн ресорт" ХХК*

Хаяг: *Булган аймгийн Могой сум, Эрхт 5-р айрт*

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл: *Дирекцлын газар*

Рашаан сувицал

Барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, /гал унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж/ анхан шатны багаж хэрэгсэл, бодис материал зэргийг байрлуулан ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно.
(Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3)

Олгосон: *2023* он *12* сар *11* өдөр

Хучинтэй хугацаа: *2025* он *12* сар *10* өдөр хүртэл

Дүгнэлт олгосон:

Булган
хуралдаа

дэргэ

аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/ цолтой *М.Баасандорж*

Дүгнэлт гаргасан:

Булган

аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/

Гал тиймрийн улсын хяналтын байцаагч *Х.Шүхрү* цолтой *Х.Чинзориг*

Гэмдэгч/арна/



САНАМЖ

Галын аюулгүй байдлын дүгнэлтийг үйлчилгээний танхимд хүний нүдэнд харагдахуйц газар байрлуулсан байна.

Галын аюулгүй байдлын дүгнэлт нь үнэт цаас учраас үрэгдүүлж, гэмтээлгүй хадгалахаас гадна хувилж, олшруулж, хуурамчаар үйлдвэрлэсэн болон бусдад түрээслэх, худалдсан тохиолдолд хариуцлага хүлээлгэнэ.

Галын аюулгүй байдлын дүгнэлт нь банкны зээлийн баталгаа, барьцаа болохгүй.

Галын аюулгүй байдлын дүгнэлт нь Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан норм, дүрэм, стандартыг зөрчсөн тохиолдолд Онцгой байдлын байгууллагын эрх бүхий албан тушаалтан хураан авах, цуцлах эрхтэй.

Галын аюулгүй байдлын дүгнэлтийн хугацаа дууссанаас хойш 1 сарын хугацаанд дахин сунгуулах.



БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
ОРХОН-ЧУЛУУТ ГОЛЫН САВ
ГАЗРЫН ЗАХИРГАА

2 дугаар баг, Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139

Утас/Факс: (976) 7033 3764,

Цахим шуудан: orhonchuluut@gmail.com

2025.03.14 № 42

танай _____-ны № _____-т

ХУЛЬЖ РЕСОРТ ХХК-Д

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал,
“рашааныг зохистой ашиглах, хамгаалах журам”-ын
3.4 дэх заалт, танай ирүүлсэн хүсэлт, холбогдох
баримт бичгийг судалж үзээд рашаан ашиглуулах
дүгнэлт гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.

Хувийг: Булган аймгийн Байгаль орчны газарт

ДАРГА



Ч.ОТГОНБААТАР

Orkhon-Chuluut GSGZ

**ОРХОН-ЧУЛУУТ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА
РАШААН АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ**

Дугаар...⁰³

2025 оны 02 дугаар
арын 18-ны өдөр

Эрдэнэбулган сум

1. Аж ахуй нэгж байгууллага, захирлын нэр, хаяг, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар

“Хульж ресорт” ХХК-ийн, Захирал Ц.Золбоо, Булган аймаг, Могод сум, 5-р баг Утас: 95190000, Улсын бүртгэлийн дугаар 000126836, регистрийн дугаар 3195767

2. Төслийн байршил:

“Хульж ресорт” Булган аймгийн Могод сумын төвийн дэргэд, Улаанбаатар хотоос 280 км, аймгийн 100 орчим км зайд оршдог. Нийт 3 га талбайд үйл ажиллагаа явуулдаг.

Орхон голын сав газарт харьяалагдана.

